

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ ЖОЛООЧ – ШУУДАНЧ

Жолооч-шууданч нь Төсөл хэрэгжүүлэх нэгжид /ТХН/ харьяалагдана.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй хүн нь В ангиллын жолооны үнэмлэхтэй, доод тал нь 5 жил жолоо барьсан туршлагатай байна. Олон улсын санхүүжилттэй байгууллагын төслийн жолооч хийж байсан туршлага нь давуу тал болно. Англи хэлний ярианы анхан шатны мэдлэгтэй байвал зохино. Ажлын аяллын маршрут зохиох, шатахууны тооцоо хийхээс гадна цаг нарийн баримталдаг, ажилч хичээнгүй, хариуцлагатай, няхуур, үнэнч шударга зан чанартай байх шаардлагатай. Жолооч нь:

- (i) Төслийн унаагаар зорчигчдын аюулгүй байдлыг хангаж ажиллах.
- (ii) Өдөр бүр ажил эхлэхээс өмнө болон ажил дууссаны дараа машинд үзлэг хийж, ажил дууссаны дараа машиныг гарашинд байрлуулж байх.
- (iii) Машинд ойр зуурын жижиг засвар хийх.
- (iv) Машины засвар үйлчилгээг хуваарийн дагуу хийлгэх, тайлагнах.
- (v) Томилолтын хуудас, замын хуудсыг тогтмол хөтөлж байх.
- (vi) НТХН-ээс гарсан баримт бичгийг яамд, бусад байгууллагад хүргэх, тэдгээрээс гарсан баримт бичгийг очиж авах.
- (vii) Төслийн хэрэгжилттэй холбоотой бусад ажил, жишээлбэл баримт бичиг олшруулах, зураг авах, дүрс бичлэг хийх, оффист жижиг засвар үйлчилгээ хийх, сургалт, семинарын бэлтгэл хангах зэрэг үйл ажиллагаа зохион байгуулахад туслах.